

## РЕДАКЦИЙН ҮГ

**Монголын Хүн Амын Сэтгүүл нь МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төвөөс 1996 онд анх "Монголын Хүн Ам Зүйн Сэтгүүл" нэртэй хэвлэгдэн гарч, өнөөг хүртэл нийт 6 дугаараа Уншигч Та бүхэнд толилуулаад байгаа билээ.**

Сэтгүүлийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, хэрэглэгчдийн хүрээг өргөтгөх зорилгоор 2001 оноос эхлэн МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төв нь Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран тус сэтгүүлийг хагас жил тутамд "Монголын Хүн Амын Сэтгүүл" нэртэйгээр эрхлэн гаргаж байна. Сэтгүүлийн энэ удаагийн дугаар Монгол Улсын Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг №203(07) дугаартайгаар уншигч та бүхэнд хүргэгдэж байгаа бөгөөд энэ нь эрдэмтэд, судлаачдын оюуны бүтээл албан ёсоор баталгаажсаны илрэл юм.

Энэхүү дугаараас Уншигч та "Судалгаа", "Сургалт", "Үзэл бодол" булангуудад нийтлэгдсэн дэлхийн болон Монгол улсын хүн ам, хөгжил, нийгмийн хүрээнд гарч буй өөрчлөлт, хандлага, тодорхой тулгамдсан асуудлуудаарх эрдэмтэд, судлаачдын судалгаа шинжилгээ, үзэл бодол, онол, арга зүйн бүтээлүүдтэй танилцах болно.

Сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлүүлэхэд байнгын дэмжлэг, тусалцаа үзүүлж байдаг НҮБ-ын Хүн Амын Санд сэтгүүлийн редакцийн хамт олны зүгээс гүн талархал илэрхийлж байна. Түүнчлэн манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн бүх Эрдэмтэн, Судлаачид болон сэтгүүлийг таалан уншдаг Уншигч олондоо талархал илэрхийлье.

Эрхэм судлаач, эрдэмтэд Та бүхнийг эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээ олны хүртээл болгоход тань манай сэтгүүл байнга туслах болох болно.

Уншигч таны мэдлэг, оюуны цар хүрээ өргөжин тэлэх болтугай.

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ